



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНД ХИЙСЭН
ШИНЖИЛГЭЭ**

Улаанбаатар хот
2023 он

ҮНДЭСЛЭЛ

НЭГ.ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

4-12

- 1.1.Эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтэц, дүрмийг батлах хүрээнд
- 1.2.Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангийн хөрөнгийг тооцох, төрийн санд байршуулах, зарцуулах журмыг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах хүрээнд
- 1.3.Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж, эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар холбогдох байгууллагаас ирүүлсэн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, санал боловсруулах, эрх бүхий этгээдээр шийдвэрлүүлэх хүрээнд
- 1.4.Эрүүл мэндийн даатгалтай холбогдсон асуудлаар өөрийн бүрэн эрхийн хүрээнд холбогдох журам, тогтоол, зөвлөмж гаргах хүрээнд
- 1.5.Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад орох тусламж, үйлчилгээний жагсаалтыг эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах хүрээнд
- 1.6.Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн тогтоох хүрээнд
- 1.7.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журмыг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах хүрээнд
- 1.8.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, чанарын болон санхүүгийн хяналтын асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий орон тооны бус техникийн хороог тухайн асуудлаар мэргэшсэн шинжээч, судлаач, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага, даатгуулагчийн оролцоотой байгуулж, ажиллах журмыг батлах, холбогдох шийдвэрийг техникийн хорооны дүгнэлт, зөвлөмжид үндэслэн гаргах хүрээнд

ХОЁР.ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

12-14

- 2.1.Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого
- 2.2.Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага
- 2.3.Эрүүл мэндийн даатгалын сангийн талаар
- 2.4.Эрүүл мэндийн даатгалын хамралтын талаар

ГУРАВ.ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

15-17

- 3.1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
- 3.2. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний

хэрэгжилтийн талаар

ДӨРӨВ. ЭМДҮЗ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ЭСЭХ ТАЛААР 17-18

ТАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ 18-20

Хүснэгт, зураг

Хүснэгт 1. ЭМДҮЗ-ийн 2022 онд баталсан тогтоолын жагсаалт

Хүснэгт 2. Эмийн хөнгөлөлтийн хувь

Хүснэгт 3. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага

Хүснэгт 4. Эрүүл мэндийн даатгалын хамралт /2020-2022/

Хүснэгт 5. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ

Зураг 1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого

Зураг 2. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага

Товчилсон үгийн жагсаалт

ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ҮАГ	Үндэсний аудитын газар

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНД ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

2023 оны 05 дугаар
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

ҮНДЭСЛЭЛ

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14¹.2 дахь хэсэгт заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл /цаашид “ЭМДҮЗ” гэх/ нь 2022 оны үйл ажиллагааны тайлангаа 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 31 дүгээр албан бичгээр Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороонд ирүүлсэн.

Улсын Их Хурлын Тамгын газраас Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.3 дахь хэсэг, Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны “Системчилсэн үнэлгээ хийх тухай” 05 дугаар тогтоолын дагуу “Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайлан” болон “2022 оны үйл ажиллагааны тайланд хийсэн системчилсэн үнэлгээний тайлан”-гийн хүрээнд шинжилгээ хийсэн болно.

Шинжилгээ хийхдээ ЭМДҮЗ-өөс ирүүлсэн дээрх 2 тайлангаас гадна Үндэсний аудитын газар (цаашид “ҮАГ” гэх)-аас гүйцэтгэсэн “Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл”-д хийсэн аудитын тайлан, “Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн”, “Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангууд, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2022 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Хараат бус судалгааны хүрээлэн болон Маастрихтын их сургуультай хамтран хийсэн “Малчдын нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын талаарх зан үйлийн судалгаа”, түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө зэрэг хөгжлийн богино, дунд хугацааны бодлогын баримт бичгийн 2022 оны хэрэгжилтийн тайлан зэрэг баримт бичгийн эх сурвалжийг ашигласан. Мөн ЭМДҮЗ-ийн ажлын албаны холбогдох ажилтантай утсаар холбогдож, шаардлагатай мэдээллийг тодруулах байдлаар нэмэлт тайлбар авч ажиллалаа.

Тайланд шинжилгээ хийх хамрах хүрээг ЭМДҮЗ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх талаар хийсэн бөгөөд танилцуулгыг дараах агуулгын хүрээнд бэлтгэсэн болно. Үүнд:

1. ЭМДҮЗ-ийн хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт;
2. Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, төсвийн гүйцэтгэл;
3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт;
4. ЭМДҮЗ үйл ажиллагаандаа системчилсэн үнэлгээ хийсэн эсэх талаар зэрэг болно.

НЭГ.ЭМДҮЗ-ИЙН ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

ЭМДҮЗ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу дараах эрх, үүргийг хэрэгжүүлэн ажилладаг байна.

Эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтэц, дүрмийг батлах, эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангийн хөрөнгийг тооцох, төрийн санд байршуулах, зарцуулах журмыг батлах, эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг төрийн санд байршуулах, зарцуулах журмыг батлах, эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж, эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар

холбогдох байгууллагаас ирүүлсэн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, санал боловсруулах, эрх бүхий этгээдээр шийдвэрлүүлэх, даатгалын гэрээний дагуу худалдан авсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын болон төлбөрийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг олон улсын эмнэл зүйн удирдамж ашиглан батлах зэрэг эрхийг хэрэгжүүлдэг.

Түүнчлэн Эрүүл мэндийн даатгалын сангийн болон эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардлын төсвийн төсөл, төсөөлөл, төсвийн хүрээний мэдэгдлийг актуар тооцоололд үндэслэн боловсруулах, батлагдсан төсвийн нарийвчилсан хуваарийг батлах, гүйцэтгэлд нь хяналт тавих, эрүүл мэндийн даатгалын сангийн болон эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны тайланг хэлэлцэх, үйл ажиллагааны болон удирдлагын зардлыг хянах, эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад орох тусламж, үйлчилгээний жагсаалтыг батлах, эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг тогтоох, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журмыг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах зэрэг чиг, үүргийн дагуу ажилладаг байна.

1.1. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтэц, дүрмийг батлах хүрээнд:

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 176 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (цаашид “ЭМДЕГ” гэх)-ын орон тооны дээд хязгаарыг 170 байхаар шинэчлэн тогтоож, ЭМДҮЗ нь 2020 оны 17 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтцийг шинэчлэн баталсан байна.

Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь бүтцийн хувьд 5 газар, 7 хэлтэс, орон нутагт 21 аймаг, 2 дүүрэгт хэлтэстэйгээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байгаа бөгөөд 2021 оноос аймаг, дүүргийн эрүүл мэндийн даатгалын тасгийг Эрүүл мэндийн даатгалын хэлтэс болгон өргөжүүлжээ.

ЭМДҮЗ-ийн 2017 оны “Эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтэц, дүрэм батлах тухай” 03 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар Эрүүл мэндийн даатгалын байгууллагын дүрмийг батлан мөрдүүлж байна. Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, эрүүл мэндийн даатгалын санг бүрдүүлэн орлого, зарлагын гүйцэтгэлийг хангаж, хяналт тавих, даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн зардлыг санхүүжүүлэх, хууль тогтоомжоор тогтоосон хугацаанд олгох, эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагаа, түүний арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар судалгаа хийх, санал боловсруулж шийдвэрлүүлэх, иргэд, даатгуулагчид Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжийг сурталчлах, ач холбогдлыг ойлгуулан таниулах замаар хамралтыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн даатгалын байгууллагын ажилтнуудын мэргэшлийг дээшлүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах, эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиглэлээр хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө нийт 7 зорилтын хүрээнд 41 ажил, үйлчилгээг **92.1 хувийн** биелэлттэй хэрэгжүүлсэн байна. Эдгээр 41 ажил, үйлчилгээнээс гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг хангасан “үр дүнтэй” буюу 100 хувь хэрэгжсэн 33 арга хэмжээ, 90 хувийн хэрэгжилттэй 7 арга хэмжээ, 80 хувийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ тус байна.

1.2. Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангийн хөрөнгийг тооцох, төрийн санд байршуулах, зарцуулах журмыг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах хүрээнд:

ЭМДҮЗ-ийн 2021 оны 10 дугаар тогтоолоор 2022 оны эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг 40 тэрбум төгрөгөөр буюу 2022 оны даатгалын санхүүжилтийн 2.8 хувиар

байгуулсан байна. 2022 оны эрсдэлийн сангийн 40.0 тэрбум төгрөгөөс эмийн үнийн хөнгөлөлтөд 8.0 тэрбум, эрүүл мэндийн үндсэн тусламж, үйлчилгээнд 32.0 тэрбум төгрөгийг тус тус зарцуулжээ. ЭМДЕГ-ын 2022 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан¹ болон Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланд ирүүлсэн мэдээлэлд Коронавируст халдварын үеийн эдийн засаг, санхүүгийн хүндрэл, инфляц, валютын ханшийн өсөлттэй холбоотой Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлэх орлого буурч, төлөвлөсөн зардлыг санхүүжүүлэхэд шаардагдах төсвийн эх үүсвэр дутагдсан тул эрсдэлийн сангийн хөрөнгийг зарцуулах шийдвэрийг ЭМДҮЗ-ийн 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн “Эрүүл мэндийн даатгалын 2022 оны эрсдэлийн сангийн хөрөнгийг зарцуулах тухай” 13 дугаар тогтоол гаргаж, эрсдэлийн сангийн 40.0 тэрбум төгрөгөөс эмийн үнийн хөнгөлөлтөд 8.0 тэрбум төгрөг, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд 32.0 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

ҮАГ-аас гүйцэтгэсэн Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланд шалгагдагч байгууллагад эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг байгуулах, сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулахтай холбоотой зөвлөмжийг хүргүүлсэн байна. Уг тайланд “Тайлант онд ЭМДС-ийн 491,583.7 сая төгрөгийн шимтгэлийн орлогын 10 хувиар 49,158.4 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санд төвлөрүүлээгүй; Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2021 оны “Коронавируст халдвар /Ковид-19/-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх журам, тусламж үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ батлах тухай” 67/А/268, А/387/99 дугаар хамтарсан тушаалуудаар сангийн хөрөнгөөс 543,036.0 сая төгрөгийг тусламж, үйлчилгээнд зарцуулсан; Төрийн болон хувийн хэвшлийн эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагууд нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжиж гүйцэтгэлээр санхүүждэг болсонтой холбоотойгоор тайлант онд 264,546.7 сая төгрөгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн өглөг үүсэж, сан алдагдалтай ажиллах эрсдэл бий болгож, үйл ажиллагааг тогтвортой байлгах асуудлыг анхаарах шаардлагатай байна”² гэж дүгнэжээ.

ЭМДҮЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны тайланд 2021 оны аудитын дүгнэлтээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх, зөрчлийг арилгах талаар гүйцэтгэсэн ажлын талаарх мэдээлэл тусгагдаагүй байна.

1.3. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж, эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар холбогдох байгууллагаас ирүүлсэн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, санал боловсруулах, эрх бүхий этгээдээр шийдвэрлүүлэх хүрээнд:

Эрүүл мэндийн даатгалын байгууллагын тогтолцоо нь Үндэсний зөвлөл, ЭМДЕГ, орон нутагт аймаг, дүүргийн эрүүл мэндийн даатгалын хэлтэс, сумын эрүүл мэндийн даатгал хариуцсан байцаагчаас бүрдэж байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14¹.2 дахь хэсэгт заасны дагуу ЭМДҮЗ нь Засгийн газрыг төлөөлсөн 3 гишүүн, ажил олгогчийг төлөөлсөн 3 гишүүн, даатгуулагчийг төлөөлсөн 3 гишүүнээс бүрддэг бөгөөд Үндэсний зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүнийг талуудын санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонгол хийж таван жилийн хугацаагаар томилж, чөлөөлдөг.

2022 онд ЭМДҮЗ-ийн ажил олгогч, даатгуулагчийг төлөөлсөн 6 гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсонтой холбогдуулан Нийгмийн бодлогын байнгын хороо Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14¹ дүгээр зүйлийн 14¹.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйл, Монгол Улсын Их

¹ Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 202 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан.
<https://emd.gov.mn/storage/legals/April2023/ZQXaMACBQMu8Gwzx5yHA.pdf>

² Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан. ҮАГ, 2022 он.

Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 123, 126 дугаар зүйлийг баримтлан нэр дэвшигчийн сонсголыг 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгуулсан.

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн зарим гишүүнийг чөлөөлөх, томилох тухай асуудлыг хэлэлцэж, Улсын Их Хурлын 2023 оны 27 дугаар тогтоолоор ЭМДҮЗ-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилсон байна.

ЭМДҮЗ-ийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан бөгөөд 2022 онд 12 удаагийн хуралдаан зохион байгуулж, нийт 24 асуудал хэлэлцэж, 18 тогтоол гаргасан байна. Тайлант онд Захиргааны ерөнхий хуулийн дагуу нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний 6 актыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулан, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн бол өөрийн дотоод үйл ажиллагаатай холбоотой 2 тогтоол, 20 тушаал гаргасан байна. Үндэсний зөвлөлийн ажлын алба нь ажлаа жилээр төлөвлөж, 2022 оны төлөвлөгөөнд 22 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд 98.2 хувийн биелэлттэй байна гэж тайлагнажээ.

ЭМДҮЗ-ийн ажлын алба нь Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны 2017 оны 27 дугаар тогтоолоор баталсан ЭМДҮЗ-ийн дүрмийн 2.4-т заасан бүтэц, орон тооны дагуу 12 орон тоонд багтааж үйл ажиллагаа явуулж байна. ЭМДҮЗ-ийн ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай асуудал холбогдох хууль тогтоомжид тусгагдаагүйгээс шалтгаалан ажлын албаны ажилтнуудын ангилал, зэрэглэлийн асуудал шийдэгдэхгүй, улмаар ажлын байранд сонгон шалгаруулалт зарлаж, шаардлага хангасан хүний нөөцийг бүрдүүлж чадахгүй, орон тоо дутуу ажиллаж байгаа талаар тайланд дурдсан байна.

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны 2019 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл болон Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны үйл ажиллагааны тайланг Байнгын хорооны хэлэлцүүлэгт бэлтгэж, санал, дүгнэлт, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн тайланг хэлэлцээд хуралдааны тэмдэглэлээр "... Үндэсний зөвлөлүүдийн ажлын албаны ажилтны ангилал, зэрэглэлийг төрийн захиргааны албан тушаалын "ТЗ" ангилал, зэрэглэлд хамруулах эсэх, цалин хөлсийг Хөдөлмөрийн тухай хуулийн хүрээнд хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр олгох, эсхүл төрийн захиргааны албан хаагчтай дүйцүүлэн олгох эсэх тухай асуудлыг холбогдох хууль, эрх зүйн баримт бичигт өөрчлөлт хийх замаар шийдвэрлэх" чиглэлийг Засгийн газарт өгсөн хэдий ч тус заалтын хэрэгжилт өнөөг хүртэл хангалтгүй байна.

Түүнчлэн эрүүл мэндийн даатгалын байгууллага нь бие даасан судалгаа, шинжилгээний нэгжтэй болгох, эрсдэлийн хяналтын тогтолцоо бий болгох зэрэг эрүүл мэндийн даатгалын байгууллагын тогтолцоог оновчтой болгох талаар салбарын мэргэжилтнүүдээс гаргасан санал, санаачилгыг судлан үзэх, улмаар эрүүл мэндийн даатгалын тогтолцоог оновчтой болгох, Байнгын хорооноос өгсөн үүрэг чиглэлийн хэрэгжилтийг хангаж зөвлөлийн ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалын ангилал, зэрэглэлийг холбогдох эрх зүйн баримт бичигт өөрчлөлт оруулж шинэчлэн тогтоох нь ажлын албаны үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явагдах нөхцөл боломжийг бүрдүүлэх юм.

Эрүүл мэндийн даатгалын цахим системийн талаар

Эрүүл мэндийн даатгалын байгууллагын төлбөр, тооцоо, даатгуулагчид болон ажил үйлчилгээ худалдан авах байгууллагуудтай харилцах, даатгалын санд хяналт тавих ажиллагаа цахим хэлбэрт бүрэн шилжсэн бөгөөд эрүүл мэндийн даатгалын цахим системд 3,993 байгууллага холбогдсон гэж тайланд дурджээ.

Иргэн, даатгуулагчид "E-Mongolia" төрийн нэгдсэн системээс 2016 оноос хойших эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээллийг харах нөхцөлийг бүрдүүлснээр

229,559 иргэн эрүүл мэндийн даатгалын лавлагаа мэдээлэл авсан байна. ЭМДҮЗ-ийн 11 дүгээр тогтоолын хүрээнд шинэчлэгдсэн эмийн жагсаалтыг өгөгдлийн санд бүртгэн, цахим программын хөгжүүлэлт, тооцооллын бодолтыг системд оруулсан байна. Системийн шинэчлэлтийн ажлын хүрээнд эрүүл мэндийн даатгалын цахим системийг Үндэсний дата төв дээрх дэд бүтцээс шинээр эрүүл мэндийн даатгалын дэд бүтэц рүү шилжүүлсэн байна.

1.4. Эрүүл мэндийн даатгалтай холбогдсон асуудлаар өөрийн бүрэн эрхийн хүрээнд холбогдох журам, тогтоол, зөвлөмж гаргах хүрээнд:

Тайлант онд Захиргааны ерөнхий хуулийн дагуу нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний 6 актыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, өөрийн дотоод үйл ажиллагаатай холбоотой 2 тогтоол, 20 тушаал баталсан байна.

Хүснэгт 1. ЭМДҮЗ-ийн 2022 онд баталсан тогтоолын жагсаалт

№	Огноо	Дугаар	Утга	Тайлбар
1	2022.01.28	01	Жагсаалт, төлбөрийн хэмжээ, арга, журам шинэчлэх батлах тухай	ЗХХАУБ-д бүртгүүлсэн №5715
2	2022.01.28	02	Журам шинэчлэн батлах тухай /сонгон шалгаруулах/	ЗХХАУБ-д бүртгүүлсэн №5716
3	2022.03.10	03	Өр төлбөр барагдуулах тухай	
4	2022.03.23	04	Тогтоолд өөрчлөлт оруулах тухай	
5	2022.03.23	05	Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэх батлах тухай	ЗХХАУБ-д Бүртгүүлсэн №5782
6	2022.04.05	06	Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай	ЗХХАУБ-д Бүртгүүлсэн №5794
7	2022.06.15	07	Журмыг шинэчлэн батлах тухай	Хүчингүй
8	2022.07.01	08	Урамшуулал олгох тухай	
9	2022.07.01	09	Тогтоолын зарим заалтын хэрэгжилтийн тухай	
10	2022.07.04	10	2022 оны төсвийн нарийвчилсан хуваарийг шинэчлэн батлах тухай	
11	2022.07.04	11	Эмийн жагсаалтыг шинэчлэн батлах тухай	ЗХХАУБ-д Бүртгүүлсэн №5910
12	2022.08.11	12	Журам шинэчлэн батлах тухай	ЗХХАУБ-д Бүртгүүлсэн №5929
13	2022.10.20	13	Эрүүл мэндийн даатгалын 2022 оны эрсдэлийн сангийн хөрөнгийг зарцуулах тухай	
14	2022.10.20	14	Тогтоолын зарим заалтын хэрэгжилтийн тухай	
15	2022.12.09	15	Урамшуулал олгох тухай	
16	2022.12.22	16	Төсвийн хуваарийг шинэчлэн батлах тухай	
17	2022.12.28	17	2023 оны төсвийн хуваарийг батлах тухай	
18	2022.12.28	18	Журам батлах тухай /Техникийн хороо/	

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, даатгалын үр өгөөжийг дээшлүүлэхэд чиглэсэн тогтоол шийдвэрүүдээс дурдвал:

- “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт”-ыг 2022 оны 01 дүгээр тогтоол;
- “Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн хөнгөлөлт зайлшгүй үзүүлэх шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ”-г 2022 оны 11 дүгээр тогтоол;

- “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам”-ыг 02 дугаар тогтоолоор тус тус батлуулан хэрэгжүүлж ажилласан байна.

Анхан шатны эрүүл мэндийн байгууллагыг санхүүжүүлэх улсын төсвийн болон эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн саланги тогтолцоог нэгтгэн, тарифыг шинэчилсэн. ЭМДҮЗ-ийн 2022 оны “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 05 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”, “Өрх, сум тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх төлбөрийн арга”, “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх, хяналт тавих журам”-ыг тус тус батлан захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн байна.

Эрүүл мэндийн салбарын хууль, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Эрүүл мэндийн даатгалын байгууллага стратегийн худалдан авагч болсны хувьд анхан шатны эрүүл мэндийн байгууллагыг санхүүжүүлэх улсын төсвийн болон эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн шийдвэрүүдийг нэгтгэн баталж, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудыг санхүүжүүлэх журмыг шинэчилснээр анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний чанар хяналтыг сайжруулах, давхардлыг арилгах, үр ашгийг сайжруулах боломжтой болсон талаар тайланд дурдсан.

Анхан шатны эрүүл мэндийн байгууллагыг санхүүжүүлэх тогтолцоог нэгтгэж, тарифыг шинэчилснээр үйлчилгээний чанар, үр ашиг сайжирсан хэдий ч хүн ам цөөтэй сумын хувьд эмнэлгийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл хангалтгүйн улмаас санхүүжилт хангалтгүй байх улмаар эмч, ажиллагсдын цалин урамшуулал зэрэг шийдвэрлэвэл зохих асуудлууд байсаар байна.

Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээг 6 насны бүлгээр багцлан, бүх насны иргэдийг хамруулах, тариф нэмэгдүүлэх шийдвэрийг гаргасан байна. ЭМДҮЗ-ийн 2022 оны 06 дугаар тогтоолоор “Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах, төлбөрийг нь санхүүжүүлэх журам”, “Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийн багц, төлбөрийн хэмжээ”-г шинэчлэн баталсан. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээний үйл ажиллагаагаар 18-аас дээш насны иргэдийг хувийн болон төрийн эмнэлгээр 12 төрлийн оношилгоо, шинжилгээ хийлгэх 43-75 мянган төгрөгийн багц гаргаж, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж байсныг өөрчилж нийт 6 насны бүлэгт 17 төрлийн өвчин эмгэгийг эрт үед нь илрүүлэх 28 төрлийн оношилгоо, шинжилгээ, үзлэгийг насны ангиллаас хамааруулан 60.0-150.0 мянган төгрөг байхаар шинэчлэн тогтоосон байна. Эрүүл мэндийн даатгалын сангаас нийт 3.3 сая тохиолдолд (давхардсан тоогоор) 16.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Капитал банкны өр төлбөрийг барагдуулах талаар шийдвэр гаргасан байна. Капитал банкны 136.1 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулах ажлын хүрээнд ЭМДҮЗ-ийн 2021 оны 06 дугаар тогтоолоор 36,5 тэрбум төгрөг, 2022 оны 03 дугаар тогтоолоор 10.2 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий нийт 46.7 тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгийг Капитал банкны эрх хүлээн авагчаас хүлээн авсан. Мөн Капитал банкны эрх хүлээн авагчаас 2020 онд 823.0 сая төгрөг, 2021 онд 7.2 тэрбум төгрөг, 2022 онд 1.7 тэрбум төгрөг, нийт 9.8 тэрбум төгрөгийг мөнгөн хөрөнгөөр хүлээн авсан байна. ЭМДҮЗ-ийн 2022 оны “Өр барагдуулах тухай” 03 дугаар тогтоолын дагуу Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас авлага барагдуулах ажлын хэсэг байгуулагдаж, Капитал банкны эрх хүлээн авагчаас хүлээн авсан 46.7 тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгөөс 2022 онд 5.6 тэрбумын төгрөгийн үл хөдлөх хөрөнгийг борлуулж Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлсэн байна.

1.5. Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад орох тусламж, үйлчилгээний жагсаалтыг эрүүл

мэндийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах хүрээнд:

ЭМДҮЗ-ийн 2022 оны “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 01 дүгээр тогтоолоор эрүүл мэндийн даатгалын сангаас төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийг өргөжүүлж, тарифыг шинэчлэн тогтоосон. 562 оношийн хамааралтай бүлгийг өдрийн мэс заслын бүлгүүдээр шинээр өргөжүүлэн 705 оношийн хамааралтай бүлэг болгож, тусламж, үйлчилгээний суурь тарифыг батлагдсан төсөвт багтааж 7 хувиар нэмэгдүүлэн шинэчлэн тогтоосон байна.

Уг тогтоолын хэрэгжилтийг Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны батлагдсан төсөвт багтаан үр ашигтай зохион байгуулах үүднээс нэн шаардлагатай бус тусламж, үйлчилгээг бууруулах, даатгуулагчдын амь насыг аврах, санхүүгийн эрсдэлээс хамгаалах, салбарын үр ашиг, бүтээмжийг дээшлүүлэх, тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэж, стратегийн худалдан авалтын бодлогыг тусгаж, яаралтай тусламж, эрчимт эмчилгээ, мэс засал, хурц үеийн эмийн эмчилгээ, эх, хүүхдийн эрүүл мэнд, сэргээн засах зэрэг салбарын тэргүүлэх чиглэлд онцгой анхаарч ажилласан байна.

Монгол Улсад эмчлэгдэх боломжгүй төлбөр өндөртэй эмчилгээний санхүүжилтийг нэмэгдүүлэн олон улсын стандартад нийцсэн үйлчилгээг цаашид эх орондоо авах нөхцөлийг бүрдүүлэх талаар салбарын мэргэжилтнүүдээс гаргаж буй санал, санаачилгыг судлан үзэж, бодлогын түвшинд стратегийн худалдан авалтыг дэмжихэд анхаарах шаардлагатай байна.

1.6. Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн тогтоох хүрээнд:

ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоолоор “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ”-г шинэчлэн тогтоосон.

Хүснэгт 2. Эмийн хөнгөлөлтийн хувь

Хөнгөлсөн эм /нийт 160/		Хөнгөлөлтийн хувь
Тоо	Хувь	
130	81.2%	25 хүртэл хувь
24	15.0%	50 хүртэл хувь
2	1.25%	75 хүртэл хувь
4	2.5%	100 хувь

Тус тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай ерөнхий нэршлийн 159, худалдааны нэршлээр 590 эмийн жагсаалтыг баталсан байна. Үнийн дээд хязгаарыг нэмэгдүүлэн шинэчлэн тогтоосон нийт 160 эмийн 81 хувь буюу 130 эмийн үнийг 25 хүртэл хувиар, 24 эмийн үнийн дээд хязгаарыг 50 хүртэл хувиар, 2 эмийн үнийн дээд хязгаарыг 75 хүртэл хувиар, 4 эмийн үнийн дээд хязгаарыг 100 хувиар тус тус нэмэгдүүлсэн байна.

“Новартис” хөтөлбөрийн хүрээнд халдварт бус өвчин эмгэгийн үед хэрэглэх 24 нэрийн эм болон 0-19 насны хүүхдэд хэрэглэх уналт, таталтын эмийг тус тус ЭМДС-аас 100 хувь бүрэн хариуцаж байна.

ЭМДС-аас 2022 оны байдлаар 1588 эмийн сангаар дамжуулан 129.8 сая ширхэг эмийг 572.5 мянган даатгуулагчид 84.2 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өмнөх оноос 14.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. ЭМД-ын сангаас эмийн үнийн хөнгөлөлтөд дунджаар 1 даатгуулагчид 143.2 мянган төгрөг зарцуулсан бөгөөд 0-5 насанд хамгийн бага буюу 11.0 мянган төгрөг, 71-80 насанд хамгийн өндөр буюу 243.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Тохиолдол судлал (https://news.mn/wp-content/uploads/2022/04/Em_infographic.pdf)

ҮАГ-аас 2022 онд хийсэн “Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитын дүгнэлтэд “Эрүүл мэндийн даатгалын сангаас зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад ороогүй эмийг хөнгөлөлттэй үнээр олгосон, зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг батлах нэгдсэн стандарт шалгуургүйгээс нотолгоонд суурилсан, эмчилгээний зааварт ороогүй эмийг жагсаалтад оруулсан нь эмийн хүртээмж, санхүүжилтийн үр нөлөөг бууруулж, эмийн үнэ олон улсын жишиг үнэтэй харьцуулахад өндөр байна. Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилт нэмэгдэж, хөнгөлөлттэй үнээр олгож буй эмийн нэр төрөл, үйлчилгээ олширсон ч мэдээллийн хүртээмж хомс, эмчилгээ хийлгэсэн хугацаа, давтамж зэрэг үр дүнгийн гүйцэтгэлийн хяналтыг орхигдуулсан, мэдээллийг нэгдсэн стандартаар цуглуулж, бүртгэж баримтжуулаагүйгээс үйлчилгээний хүрээ хязгаарлагдмал, хөтөлбөр, арга хэмжээ, санхүүжилтийн үр нөлөөг тооцох боломжгүй байна.”¹ гэж дүгнэсэн байна.

Түүнчлэн эмийн үнийн хөнгөлөлттэй холбоотой иргэд, олон нийтийн дунд шүүмжлэл дагуулдаг эмийн хүртээмж, санхүүжилт, эмийн үнэ ханш, голлон зонхилдог өвчний эмүүдийг өндөр хувиар хөнгөлөх зэрэг асуудлыг цаашид шийдвэрлэхэд анхаарах шаардлагатай.

1.7. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журмыг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах хүрээнд:

ЭМДҮЗ-ийн 2022 оны 02 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам”-ыг шинэчлэн баталж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн байна. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа, тусгай зөвшөөрөлтэй, магадлан итгэмжлэгдсэн өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагаас тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, хүртээмжийг нь харгалзан сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулах журам шинэчлэгдсэнээр сонгон шалгаруулалтын тогтолцоонд томоохон өөрчлөлтийг бий болсон гэж онцолсон байна.

Сонгон шалгаруулалтад оролцогч байгууллагуудад эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний оношийн бүлэг тус бүрээр тухайн тусламж, үйлчилгээг үзүүлэхэд зайлшгүй шаардлагатай нөөц шаардлагыг тавьж өгснөөр даатгуулагчид үзүүлэх тусламж, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх боломжтой юм.

1.8. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, чанарын болон санхүүгийн хяналтын асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий орон тооны бус техникийн хороог тухайн асуудлаар мэргэшсэн шинжээч, судлаач, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага, даатгуулагчийн оролцоотой байгуулж, ажиллах журмыг батлах, холбогдох шийдвэрийг техникийн хорооны дүгнэлт, зөвлөмжид үндэслэн гаргах хүрээнд:

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, чанарын болон санхүүгийн хяналтын асуудлаар дүгнэлт зөвлөмж гаргах орон тооны бус техникийн хороо байгуулагдаагүй байна. Техникийн хороог байгуулах ажлын хүрээнд 2022 онд тус техникийн хорооны ажиллах журмын төслийг боловсруулж, ЭМДҮЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 18 дугаар тогтоолоор баталсан байна. Техникийн хороог сонгон шалгаруулах ажил зохион байгуулалтаас шалтгаалан хүлээгдэж байна.

Техникийн хороог байгуулах нь даатгалд хамрагдах эмчилгээний аргыг сайжруулахаас гадна эмнэлгийн тусламж, үйлчилгээний хяналтыг сайжруулах, үр нөлөөг

нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой тул цаашид тус чиг үүргийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд анхаарч ажиллах нь зүйтэй.

ХОЁР.ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1.Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого:

Зураг 1.



Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулиар эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 1450.7 тэрбум төгрөгөөр батлагдсан. 2022 оны гүйцэтгэлээр нийт 1,224.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 84.4 хувьтай байна.

Гүйцэтгэлээр нийт 1,224.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлснээс:

- аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч, даатгуулагчийн төлөх шимтгэл 511.5 тэрбум төгрөг;
- эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг өөрөө хариуцан төлөгч иргэд 25.0 тэрбум төгрөг;
- төр даатгалыг нь хариуцах иргэдийн шимтгэл 163.7 тэрбум төгрөг;
- төр хариуцах тусламж, үйлчилгээнд улсын төсвөөс 540.4 тэрбум төгрөг;
- бусад орлого 2.4 тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Зураг 2.



2.2.Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага:

Зураг 3.



Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулиар эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагыг 1481.4 тэрбум төгрөгөөр батлагдсан. Энэ хүрээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардалд 1,358.0 тэрбум төгрөгийг гүйцэтгэлээр тооцон олгож, эмийн үнийн хөнгөлөлтөд 67.2 тэрбум төгрөг, үйл ажиллагааны зардалд 14.1 тэрбум төгрөг, Нийгмийн даатгалын байгууллагад олгох орлого цуглуулах үйл ажиллагааны зардалд 1.1 тэрбум төгрөг тус тус олгожээ.

Хүснэгт 3. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага

	Зарлага	2022 оны гүйцэтгэл /сая.төгрөг/	Нэмэлт санхүүжилт /сая.төгрөг/	Нийт /сая.төгрөг/
1	Тусламж, үйлчилгээний зардал	1,358,074.7	266,917.6	1,624,992.3
2	ЭМДСангаас эмийн үнийн хөнгөлөлт	67,299.9	17,062.4	84,362.4
3	Үйл ажиллагааны зардал	14,129.1	-	14,129.1
4	НДЕГ-т олгох	1,100.0	-	1,100.0

5	Илүү төлсөн шимтгэлийн буцаан олголт	348.5	-	348.5
6	Эрсдэлийн сангийн хөрөнгө	40,000.0	-	40,000.0
7	Бусад	-	-	-
	Нийт	1,480,952.2	283,980.0	1,764,932.3

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагыг 2021 онтой харьцуулахад 272.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Монгол Улсын Засгийн газар, Сангийн яам, Эрүүл мэндийн яамны шийдвэрээр 2022 онд Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед иргэний эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх, хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэмийн үед эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтэд шаардлагатай эмнэлгийн тусламж, үйлчилгээний зардлыг шийдвэрлэж, эмнэлгийн тусламж, үйлчилгээг өр төлбөр үүсгэхгүй байхаар төлөвлөж санхүүжүүлэн, эрүүл мэндийн байгууллагуудын гүйцэтгэлд үндэслэн 283.9 тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилтийг шийдвэрлэж, нийт 1,749.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг эрүүл мэндийн байгууллагуудад олгосон байна. Түүнчлэн 2022 оны эрсдэлийн сангийн 40.0 тэрбум төгрөгөөс эмийн үнийн хөнгөлөлтөд 8.0 тэрбум, эрүүл мэндийн үндсэн тусламж, үйлчилгээнд 32.0 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

2.3. Эрүүл мэндийн даатгалын сангийн талаар:

Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох чиг үүргийн хүрээнд улсын төсвийн болон эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн саланги тогтолцоог нэгтгэсэн. Эрүүл мэндийн санхүүжилтийн шинэчлэлийн үйл явц нь эрүүл мэндийн даатгалын сангаар дамжин хэрэгжиж байгаатай холбогдуулан өмнө төрөөс шууд хариуцаж байсан тусламж, үйлчилгээний хяналт сайжирч, Эрүүл мэндийн даатгалын байгууллага болон иргэдийн хяналт, мэдээлэл сайжирч, улмаар иргэд өөрөөс гаргасан зардлыг нөхөн төлүүлэх зэрэг эерэг үр дүн гарч байна. 2022 онд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний 9.3 сая тохиолдолд /давхардсан тоогоор/ гүйцэтгэлээр нь тооцож нийт 1,749.3 их наяд төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

ЭМДС-аас олгосон санхүүжилтийг эрүүл мэндийн байгууллагын төрлөөр 2021 онтой харьцуулахад олгосон санхүүжилт улсын эмнэлэгт 47 хувиар, хувийн эмнэлэгт 37 хувиар, сувилалд 130 хувиар, өрхийн эрүүл мэндийн төвд 38 хувиар, сум, тосгоны эрүүл мэндийн төвд 18 хувиар, эмийн санд 57 хувиар тус тус нэмэгдсэн байна.

2.4. Эрүүл мэндийн даатгалын хамралтын талаар:

2022 онд эрүүл мэндийн даатгалд 3,200.5 мянган даатгуулагч хамрагдаж, хамрагдалт 92.5 хувьтай байгаа нь 2021 онтой харьцуулахад 143.4 мянгаар буюу 1.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 4. Эрүүл мэндийн даатгалын хамралт /2020-2022/

д/д	Хамралтын төрөл	Даатгуулагчийн тоо /мянган хүн/		
		2020 он	2021 он	2022 он
1	Аж ахуйн нэгж байгууллагын ажиллагч	797.5	566.0	749.3
2	Малчин	76.1	51.3	52.0
3	Аж ахуйн нэгжийн эзэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, ажилгүй иргэн	163.1	122.0	133.9
4	Их, дээд сургууль болон мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд суралцагч	24.9	13.5	14.3
5	Ял эдэлж байгаа ялтан	-	-	4.6
6	Гадаадын харьяалалтай иргэн/Бусад	0.3	0.5	0.6
7	ЭМД-ыг төрөөс хариуцдаг иргэн	2 034.3	2303.2	2245.8
	Нийт	3096.2	3057.1	3200.5
	Хамралтын хувь	93.0%	91.1%	92.5%

Даатгуулагчдын тоо өссөн шалтгааныг аймаг, орон нутгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсүүд тухайн аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэстэй үйл ажиллагаагаа уялдуулан хамтран ажиллаж, эрүүл мэндийн даатгалын хамралт, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний талаар даатгуулагчдад сургалт, сурталчилгаа хийх ажлыг зохион байгуулсны үр дүн гэж үзсэн байна.

ЭМДҮЗ-ийн 2021 оны үйл ажиллагааны тайланд “2021 онд 3.251.4 мянган даатгуулагч эрүүл мэндийн даатгалд хамрагдаж, хамралтын түвшин 96.8 хувьтай байна³” гэж тайлагнасан бөгөөд тус байгууллагын 2021, 2022 оны үйл ажиллагааны тайланд дурдсан даатгалд хамрагдагчдын тоо, мэдээлэл зөрүүтэй байна.

ЭМДҮЗ-ийн хэрэгжүүлсэн бодлого, гүйцэтгэсэн ажлын үр дүн нь эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого, эрүүл мэндийн даатгалд хамрагдалтаар илэрхийлэгдэх бөгөөд тайланд салбарын голлох үзүүлэлтийг ийнхүү зөрүүтэй байдлаар тайлагнаж байгаа нь хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагааны үр дүнг үнэлэхэд хүндрэлтэй байна.

Монгол Улсын урт, дунд богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд ч эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн тоо хэмжээг нэмэгдүүлэх зорилт, арга хэмжээ тусгагдаж ирсэн бөгөөд эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн хамрагдалт 92.5 хувьтай байгаа нь тухайлбал, Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан “эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн хамрагдалт 95 хувьд хүрсэн байна.” гэсэн зорилтот түвшинд хүрээгүй байна.

Шуигтгээ /судалгааны дүн/

2022 онд Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Хараат бус судалгааны хүрээлэн болон Маастрихтын их сургуультай хамтарсан “Малчдын нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын талаарх зан үйлийн судалгаа”-нд Малчид эрүүл мэндийн даатгалд хамрагдахгүй байгаа гол шалтгааныг тодруулан асуухад “эрүүл мэндийн даатгал ач холбогдолгүй мөн үнэтэй” гэсэн хариулт нийтлэг дурдагдсан байна.

ЭМД-д тэдний хамрагдахгүй байгаа шалтгаан нь нас, хүйс, орлогын түвшин зэргээс хамаарч харилцан адилгүй байна. Одоогоор ЭМД-д хамрагдаагүй байгаа малчдын хувьд дурдагдсан хамгийн нийтлэг хоёр шалтгаан нь ЭМД чухал бус (27%), ЭМД үнэтэй (22%) гэсэн хариултауд байна.

... Насны бүлгийн хувьд 34 хүртэлх насны малчин залуучууд “ЭМД-д хэрхэн хамрагдах талаар мэддэггүй” гэсэн хариултыг нийтлэг өгсөн бол, 35 болон түүнээс дээш насны малчдын хувьд “хэтэрхий үнэтэй” гэсэн хариулт мэдэгдэхүйц өндөр байна.⁴

2022 онд эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг сурталчлах, иргэд, олон нийтэд мэдээ, мэдээлэл хүргэх чиглэлээр ЭМДЕГ-ын албан ёсны www.emd.gov.mn цахим хуудас, хөдөлгөөнт постер, видео контентыг тогтмол бэлтгэн ЭМДЕГ-ын сошиал хаягуудаар дамжуулан иргэд, олон нийтэд мэдээлэн ажилласан байна. Даатгалд хамрагдагчдын өсөлт болон холбогдох судалгааны дүн зэргээс үзэхэд Эрүүл мэндийн даатгалд хамрагдах иргэдийн тоог нэмэгдүүлэхийн тул иргэдэд үйлчлэх үйлчилгээг илүү сайжруулах, боловсронгуй болгох, даатгалын тухай ойлголт, ач холбогдол түүнчлэн даатгал төлснөөр авч болох үйлчилгээний талаарх мэдээллийг нийтэд түгээх мэдээлэл, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

³Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны тайлан. ЭМДҮЗ-ийн 2022.03.30-ны өдрийн 23 дугаар албан бичиг.

⁴“Малчдын нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын талаарх зан үйлийн судалгаа”. Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Хараат бус судалгааны хүрээлэн болон Маастрихтын их сургууль. 2022.

https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/---ilo-beijing/documents/publication/wcms_847374.pdf

ГУРАВ.ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

3.1.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар:

Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 79 хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийн 210 заалтыг хяналтад авсан байна. Үүнд: Монгол Улсын 5 хуулийн 41 заалт, Монгол Улсын Их Хурлын 4 тогтоолын 9 заалт, Засгийн газрын 15 тогтоолын 34 заалт, Засгийн газрын 18 хуралдааны тэмдэглэлийн 34 заалт, Засгийн газрын 6 албан даалгаврын 16 заалт, ЭМДҮЗ-ийн 19 тогтоолын 53 заалт, Эрүүл мэндийн сайдын 12 тушаалын 23 заалтын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хяналтад авсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн дундаж 97.5 хувьтай байна гэж тайлагнасан.⁵

Улсын Их Хурлын Тамгын газраас ЭМДҮЗ-ийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3-т заасан аргачлалын дагуу үнэлэхэд Монгол Улсын хуулиар үүрэг чиглэл болгосон 5 хуулийн 41 заалтын хэрэгжилт 96.2 хувь, Улсын Их Хурлын 4 тогтоолын 9 заалтын хэрэгжилт 100.0 хувьтай байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9.12-т “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, чанарын болон санхүүгийн хяналтын асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргах орон тооны бус техникийн хороог байгуулах, ажиллах журмыг батлах” чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байна. Тус заалтын хэрэгжилтийг “эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, чанарын болон санхүүгийн хяналтын асуудлаар дүгнэлт зөвлөмж гаргах орон тооны бус техникийн хороог байгуулах, ажиллах журмын төслийг боловсруулан ЭМДҮЗ-ийн ажлын албанд хүргүүлсэн” гэж тайлагнасан. Тус журмыг ЭМДҮЗ-ийн 2022 оны 18 дугаар тогтоолоор баталсан байна. Харин техникийн хороо байгуулагдаагүй, үр дүнд хүрээгүй тул хэрэгжих шатанд буюу 70 хувийн хэрэгжилттэй гэж үнэллээ.

Мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-т тусгагдсан “Үндэсний зөвлөл нь эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны тайланг жил бүр, эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүгийн тайланг улирал бүр хэлэлцэн холбогдох асуудлаар шийдвэр гаргана.” гэсэн заалтын хэрэгжилтийг “... Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланг ЭМДҮЗ-ийн хурлаар оруулахаар бэлтгэж байна” гэж тайлагнасан байна. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны тайлан, эрүүл мэндийн даатгалын сангийн улирал тутмын тайлан хэлэлцсэн эсэх талаар мэдээлэл хангалтгүй тул тус заалтын хэрэгжилтийг 30 хувь гэж үнэллээ.

Цаашид Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоолоор өгсөн үүрэг, чиглэлийн хэрэгжилтийг ирүүлэхээс гадна Байнгын хорооны тогтоол болон хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг, чиглэлийн хэрэгжилтийг тайланд тусган ирүүлэх шаардлагатай байна.

3.2.Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн талаар:

Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд эрүүл мэндийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох, санхүүжилтийн оновчтой хэлбэрийг нэвтрүүлэхтэй холбоотой зорилт, арга хэмжээ тусгагддаг. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд эдгээр зорилт, арга хэмжээний хэрэгжилт хэрхэн туссан байгааг харьцуулан үзлээ.

⁵ Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайлан. ЭМДҮЗ-ийн 2023.04.28-ны өдрийн 31 дүгээр албан бичиг.

Хүснэгт 5. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ

Бодлогын баримт бичиг	Зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ
Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	2.1.7.Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой арга, хэлбэрийг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлж, эрсдэлийн сан байгуулна.	1.Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сан байгуулна.
		2.Төр хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад Улсын төсөв /ЭМДС/гаас амбулатори, өдрийн эмчилгээ, оношилгоонд олгох санхүүжилтийн ялгааг арилгана.
		3.Урт хугацааны тусламж, үйлчилгээний загвар гаргаж, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаар гүйцэтгүүлэн Улсын төсөв /ЭМДС/гаас санхүүжүүлнэ.
		4.Эмнэлгийн хагас бие даасан байдлыг эрүүл мэндийн байгууллагуудад үе шаттай нэвтрүүлнэ.
		5.Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг эрүүл мэндийн байгууллагад нэвтрүүлнэ.
		6.Санхүүжилтийн гүйцэтгэл, удирдлагын хагас бие даасан байдалтай уялдуулан эрүүл мэндийн байгууллагуудын хөгжлийн төлөвлөлтийг хэрэгжүүлнэ.
		7.Эрүүл мэндийн үндэсний тооцоо болон тусламж, үйлчилгээний тариф тогтооход ашиглах зорилгоор тусламж, үйлчилгээний өртгийн бүртгэлийн цахим тогтолцоог эрүүл мэндийн байгууллагуудад нэвтрүүлнэ.
		8.ЭМДЕГ-ын бүтцийг оновчтой болгож, хүний нөөцийг чадавхжуулна.
		9.Төрөөс болон ЭМД-аас хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний өртөг, багц, төлбөрийн хэмжээг тогтоох, зардлын тооцооллыг хийнэ.
		10.Эрүүл мэндийн даатгалыг цахимжуулна.
		11.Төрөөс хариуцах иргэдийн шимтгэл, албан бус салбарын даатгуулагчдын хамрагдалт, шимтгэлийн хэмжээг өсгөх замаар Улсын төсөв /ЭМДС/гийн орлогыг нэмэгдүүлнэ.
		12.Олон улсын эмнэл зүйн удирдамжийн цахим санг нэвтрүүлнэ.
Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө	2.1.12	Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн хамрагдалтыг нэмэгдүүлэх.
	2.1.24	Эрүүл мэндийн даатгалыг цахимжуулах.
	2.1.27	Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг байгуулах.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Хүний хөгжлийн бодлогын хүрээнд “Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой арга, хэлбэрийг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлж, эрсдэлийн сан байгуулна” гэсэн зорилт дэвшүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилтийн тайланд тус зорилтыг хэрэгжүүлэх төлөвлөсөн арга хэмжээнүүдээс Эрүүл мэндийн даатгалыг цахимжуулах, ЭМДЕГ-ын бүтцийг оновчтой болгож, хүний нөөцийг чадавхжуулах, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг эрүүл мэндийн байгууллагад нэвтрүүлэх зэрэг арга хэмжээ нь зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй ч “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70-99 хувийн хэрэгжилттэй байна.

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний Хүний хөгжлийн бодлогын хүрээнд Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн хамрагдалтыг нэмэгдүүлэх, Эрүүл мэндийн даатгалыг цахимжуулах, Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг байгуулах зэрэг эрүүл мэндийн даатгалын тогтолцоотой холбоотой 3 зорилт дэвшүүлсэн бөгөөд Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн хамрагдалтыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн даатгалыг цахимжуулах зорилт 2022 онд “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70-99 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

Дээрх хоёр бодлогын баримт бичигт тусгагдсан Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг байгуулах гэсэн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг “ЭМДҮЗ-ийн 2021 оны 10 дугаар тогтоолоор эрсдэлийн санг 40.0 тэрбум төгрөгөөр буюу 2022 оны даатгалын санхүүжилтийн 2.8 хувиар байгуулсан байна. Коронавируст халдварын үеийн эдийн засаг, санхүүгийн хүндрэл, инфляци, валютын ханшийн өсөлттэй холбоотой Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлэх орлого буурч, төлөвлөсөн зардлыг санхүүжүүлэхэд шаардагдах төсвийн эх үүсвэр дутагдсан тул эрсдэлийн сангийн хөрөнгийг зарцуулах шийдвэрийг Эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн “Эрүүл мэндийн даатгалын 2022 оны эрсдэлийн сангийн хөрөнгийг зарцуулах тухай” 13 дугаар тогтоолоор гаргажээ.” гэж тайлагнасан. Тус арга хэмжээ нь зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага зохион байгуулалтыг сайжруулах шаардлагатай тул “30 хувь” гэж үнэлсэн.

ДӨРӨВ.ЭМДҮЗ НЬ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ЭСЭХ ТАЛААР

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны “Системчилсэн үнэлгээ хийх тухай” 05 дугаар тогтоолоор Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагуудад үйл ажиллагааны тайлангаа Улсын Их Хуралд ирүүлэхдээ “Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийж ирүүлэх үүрэг, чиглэл өгсний дагуу ЭМДҮЗ нь 2022 оны үйл ажиллагааны тайландаа системчилсэн үнэлгээ хийж ирүүлсэн байна.

Системчилсэн үнэлгээний зорилго нь байгууллагын үйл ажиллагааны үр өгөөж, өөрийн тавьсан зорилгодоо ямар хэмжээнд хүрсэн байдлыг тодорхойлох буюу тухайн байгууллагын дотоод үйл ажиллагааг үнэлэхэд чиглэгддэг.

Системчилсэн үнэлгээний тайланг байгууллагын чиг үүргийн үнэлгээ, байгууллагын үйл ажиллагааны журмын /процессын/ үнэлгээ, хүний нөөцийн хэрэгцээний үнэлгээ, санхүүгийн буюу захиргааны зардлын үнэлгээ гэсэн үнэлгээний төрлүүдийн алийг нь сонгон хийсэн талаар мэдээлэл байхгүй байна. Харин системчилсэн үнэлгээ хийх болсон зорилгыг “байгууллагын үйл ажиллагааны үр өгөөж, өөрийн тавьсан зорилгод ямар хэмжээнд хүрснийг тодорхойлоход чиглэнэ” гэж тодорхойлж, “дотоодын буюу өөрийн үнэлгээ”-ний хэлбэрийг сонгож хийсэн байна.

Байгууллагын хүний нөөцийн үнэлгээг хийхдээ хүний нөөцийн хэрэгцээ, хангамжид хийсэн дүгнэлт байхгүй, зайлшгүй шаардлагатай асуудлыг тусгаагүй, хэт ерөнхий мэдээллээр тайлагнасан байна. Тухайлбал, “Эрүүл мэндийн даатгалын байгууллагад нийт 204 ажилтан, албан хаагч ажиллаж байна. Удирдах албан тушаалтан 33, гүйцэтгэх албан тушаалтан 171 байна. Төрийн захиргааны албан хаагчаас эрхэлсэн түшмэл 1, ахлах түшмэл 27, дэс түшмэл 80 байна.” гэж тайлагнасан байна.

“Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу ЭМДҮЗ нь байгууллагын хүний нөөцийн үнэлгээг тухайн үйл ажиллагааны төрөл, зарцуулж байгаа хугацаа, давтамжтай уялдуулан байгууллагын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг тодорхойлох шаардлагатай байсан.

Системчилсэн үнэлгээгээр ЭМДҮЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны тайлангийн анхаарах асуудал хэсэгт ЭМДҮЗ-ийн ажлын албаны ажилтнуудын ангилал, зэрэглэлийн талаарх заалт холбогдох хууль тогтоомжид тусгагдаагүйгээс ажлын албаны ажилтнуудын ангилал, зэрэглэлийн асуудал шийдэгдэхгүй, ажлын байранд сонгон шалгаруулалт зарлаж, шаардлага хангасан хүний нөөцийг бүрдүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдээгүйгээс орон тоо дутуу ажиллаж байгааг гаргаж тавьсан. Мөн ЭМДҮЗ-ийн дүрэмд ажлын албаны албан тушаалын нэршлийг өөрчилж, төрийн захиргааны албан хаагчийн статустай байхаар бүтцийн өөрчлөлт хийх санал гаргажээ.

Байгууллагын үндсэн үйл ажиллагааг үнэлэхдээ ЭМДС-ийн төсөв, түүний гүйцэтгэл, даатгалын шимтгэлийн хувь хэмжээ, даатгалын хамралт, даатгалын хяналт, цахимжилт, сургалт, сурталчилгааны талаар тайланд дурдсан гол тоон үзүүлэлтийн мэдээллийг харуулсан бол салбарын эрх зүйн орчны үнэлгээгээр хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээг харуулахаас гадна тухайн онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний ололттой талыг илрүүлж, цаашид анхаарах асуудлын талаарх саналыг өнөөгийн нөхцөл байдалд хийх дүн шинжилгээгээр гаргаж тавьсан нь байна.⁶

Эрүүл мэндийн даатгалын сангийн үйл ажиллагаатай холбоотой 187 мэдээлэл, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 184 мэдээлэл нийт 371 мэдээллийг шилэн дансанд байршуулсан бөгөөд 24 мэдээллийг хугацаандаа тайлагнаагүй байна.

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хүрээнд Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалтад салбарын ажилтнуудын хамрагдалт сайн байгаа бол Төрийн хэмнэлтийн хуультай холбоотойгоор гадаад сургалтад хамруулсан ажилтны тоо 2022 онд багассан байна.

Системчилсэн үнэлгээнд үндэслэн цаашид анхаарах шаардлагатай 6 асуудлыг тодорхойлсон байна. Үүнд:

- Даатгалын сангийн зарцуулалтад хяналт тавих эрх бүхий этгээдийг зааглан тогтоох, хяналтын тогтолцоог оновчтой болгох;
- Зорилтот хэрэглэгчдэд санхүүгийн эрсдэл үүсэх, ЭМДСанд яваандаа ачаалал бий болох зэрэг эрсдэлээс сэргийлэх зорилгоор Засгийн газраас эмийн үнийг тогтоох хуулиар олгосон чиг үүргийн хэрэгжилтийг хангах;
- ЭМДҮЗ-ийн ажлын албаны бүтцийг өөрчлөх, ажлын албаны ажилтнуудын ангилал, зэрэглэлийг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх;
- ЭМДҮЗ-ийн дүрмийн зарим зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх зэрэг зайлшгүй шаардлагатай асуудлыг тусгасан байна.

Даатгалын сангийн зарцуулалтад хяналт тавих эрх бүхий этгээдийг ялгамжтай тогтоох, хяналтын тогтолцоог оновчтой болгох, ЭМДҮЗ-ийн дүрмийн зарим зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх зэрэг асуудал нь ЭМДҮЗ-ийн 2021, 2022 оны үйл ажиллагаанд хийсэн системчилсэн үнэлгээний тайланд дахин дурдагдаж байгаад анхаарч энэ чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай байна.

ТАВ.ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.3 дахь хэсэг, Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны “Системчилсэн үнэлгээ хийх тухай” 05 дугаар тогтоолын дагуу “Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайлан” болон “2022 оны үйл ажиллагааны тайланд хийсэн системчилсэн үнэлгээний тайлан”-гийн хүрээнд Улсын Их Хурлын Тамгын газраас шинжилгээ хийж, дараах дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Дүгнэлт

1. ЭМДҮЗ-ийн 2021 оны 10 дугаар тогтоолоор 2022 оны эрсдэлийн санг 40 тэрбум төгрөгөөр буюу 2022 оны даатгалын санхүүжилтийн 2.8 хувиар байгуулсан байна.

⁶ Системчилсэн үнэлгээгээр үйл ажиллагааны хэрэгжилтийн үр дүнг судалж, чиг үүргийг агуулгын хувьд нягталж, тэдгээрийг харьцуулах, задлан шинжлэх ажиллагааг хийдэг. “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр дүнг үнэлэхдээ төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн биелэлт, байгууллагын ил тод байдлын үнэлгээ, шилэн дансны хөтлөлт, байгууллагын шударга байдлын үнэлгээ, салбарын хөгжлийн үзүүлэлт зэрэг үзүүлэлтийг гол хэмжүүр болгон ашигладаг.

Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлэх орлого буурч, төлөвлөсөн зардлыг санхүүжүүлэхэд шаардагдах төсвийн эх үүсвэр дутагдсан тул эрсдэлийн сангийн хөрөнгийг зарцуулах шийдвэрийг ЭМДҮЗ-ийн 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн “Эрүүл мэндийн даатгалын 2022 оны эрсдэлийн сангийн хөрөнгийг зарцуулах тухай” 13 дугаар тогтоолоор гаргаж, 2022 оны эрсдэлийн сангийн 40.0 тэрбум төгрөгөөс эмийн үнийн хөнгөлөлтөд 8.0 тэрбум, эрүүл мэндийн үндсэн тусламж, үйлчилгээнд 32.0 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна;

2. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 84.4 хувийн биелэлттэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ЭМДС-аас олгосон санхүүжилт улсын эмнэлэгт 47 хувиар, хувийн эмнэлэгт 37 хувиар, сувилалд 130 хувиар, өрхийн эрүүл мэндийн төвд 38 хувиар, сум, тосгоны эрүүл мэндийн төвд 18 хувиар, эмийн санд 57 хувиар тус тус нэмэгдсэн байна;
3. 2022 онд малчин, оюутан, ажилгүй иргэн тус бүрээр сүүлийн 3 жилийн статистик судалгаа хийж, эрүүл мэндийн даатгалд хамруулах төлөвлөгөөг гарган ажилласны үр дүнд эрүүл мэндийн даатгалд 3,200.5 мянган даатгуулагч хамрагдаж, хамрагдалт 92.5 хувьтай буюу өмнөх оноос 1.4 хувиар өссөн байна. Гэвч даатгалын тухай ойлголт, ач холбогдол түүнчлэн даатгалын төрөл үйлчилгээний талаарх мэдээлэл олон нийтэд хангалтгүй байх тул цаашид мэдээллийг түгээх, сурталчлан таниулах ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна;
4. ЭМДҮЗ-ийн 2019 оны үйл ажиллагааны тайланг Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороогоор хэлэлцээд ЭМДҮЗ-ийн ажлын албаны ажилтны ангилал, зэрэглэлийн асуудлыг холбогдох хууль, эрх зүйн баримт бичигт өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх талаар Засгийн газарт чиглэл өгсөн хэдий ч хэрэгжилт хангалтгүй байна;
5. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, чанарын болон санхүүгийн хяналтын асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий орон тооны бус техникийн хороог тухайн асуудлаар мэргэшсэн шинжээч, судлаач, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага, даатгуулагчийн оролцоотой байгуулж, ажиллах журмыг батлах, холбогдох шийдвэрийг техникийн хорооны дүгнэлт, зөвлөмжид үндэслэн гаргах гэсэн хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй, техникийн хороо байгуулагдаагүй байна;
6. ЭМДҮЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны тайланд Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх, зөрчлийг арилгах чиглэлд хийсэн ажлын талаарх мэдээлэл тусгагдаагүй байна.

Зөвлөмж

1. Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооноос өгсөн үүрэг, чиглэлийн хэрэгжилтийг хангаж хангаж зөвлөлийн ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалын ангилал, зэрэглэлийг холбогдох эрх зүйн баримт бичигт өөрчлөлт оруулах талаар санал боловсруулж, шийдвэрлүүлэх;
2. Техникийн хороог байгуулах нь даатгалд хамрагдах эмчилгээний аргыг сайжруулахаас гадна тусламж, үйлчилгээний хяналтыг сайжруулах, үр нөлөөг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой тул тус заалтын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар анхаарч ажиллах;
3. Эрүүл мэндийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх, даатгалын тухай ойлголт, ач холбогдол, даатгалын үйлчилгээний төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч, энэ талаарх мэдээллийг олон нийтэд түгээх мэдээлэл, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх;

4. Цаашид ЭМДҮЗ-ийн хуулиар хүлээсэн чиг үүрэгт хамаарах Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоолоор өгсөн үүрэг, чиглэлийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг ирүүлэхээс гадна Байнгын хорооны тогтоол болон хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг, чиглэлийн хэрэгжилтийг тайланд тусган ирүүлэх шаардлагатай байна.

---000---